



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 10/60

Чингис хот

Аюулгүйн нөөц бүрдүүлэхэд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Засгийн газрын "Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай" 2019 оны 285 дугаар тогтоол, 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн "Аймгийн аюулгүйн нөөц нөхөн бүрдүүлэх тухай" хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын 2020 оны 1 дүгээр хуралдааны шийдвэрийн дагуу өвс тэжээлийн аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд 39200000 /гучин есөн сая хоёр зуун мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг аймгийн Малын эрсдлээс хамгаалах сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010168

Аймгийн Засаг даргын 2020 оны  
...<sup>02</sup> дугаар сарын ...<sup>04</sup> өдрийн ...<sup>160</sup>...  
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Өвс	8000	4900 боодол	39200000
	Нийт зардал			39200000